



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар

1/211

Улаанбаатар хот

Хүүхдийн тоглоомын талбайд хяналт
шалгалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07, 2025 оны "Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал-2028" арга хэмжээ батлах тухай 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, өсөж хөгжих нөхцөл боломжийг бий болгох зорилгоор дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх хүүхдийн тоглоомын талбай, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын орчны аюулгүй байдалд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010621

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025
оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/341
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Дүүргийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга Дүүргийн Цагдаагийн газрын дарга Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд Дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын Эрхлэгч нар
Нарийн бичиг:	Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга